



**ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2025 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

| Д/д | Зорилго  | Хэрэгжүүлэх арга хэмжээ   | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт   | Хүрэх түвшин  | Төсөв                  | Хугацаа    | Хэрэгжүүлэх нэгж | Хамтран хэрэгжүүлэх |
|-----|--|---|---|---|------------------------|------------|------------------|---------------------|
| 1   | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | 1.1. Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг а/байгууллагын албан ёсны цахим хуудас; б/сошиал сувгууд; в/дотоод сүлжээ; г/хэвлэл мэдээллийг хэрэгсэл, д/мэдээлэл сурталчилгаа самбар, лед дэлгэц, е/бусад хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх;                                | - Тогтмол шинэчлэн, байршуулах;<br><br>- Харьяа нэгжүүдийг нэгэн зэрэг хамруулж, үр дүнг ттон мэдээллээр нэгтэн тайланд тусгах;   | - Nema.gov.mn сайт, Онцгой байдлын ерөнхий газар болон төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын facebook хуудас, санд АТГ-аас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг тухай бүр нийтэлж, түгээх ажлыг зохион байгуулсан байна. | -                      | Тухай бүр  | ЗЭЗХНГ ЗУГ       | ТОНОББ              |
|     |  | 1.2. Өөрийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг хэвлэмэл материал, зэрэгт авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулж сурталчлах; | - Мэдээллийг Авлигатай тэмцэх газраас буюу баталгаат эх сурвалжаас авсан байх;<br>- Байгууллагын эрх хэмжээний хүрээнд иргэд, олон нийт рүү чиглэсэн хэвлэмэл материалд оруулсан байх;<br>- Ном гарын авлага, сэтгүүл цахим хэлбэрт оруулж, QR code | - Онцгой мэдээ сонин, Гамшиг судлалын инновац улирал тутмын сэтгүүлд авлигын хор хөнөөлийг ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан мэдээ мэдээллийг оруулах, мөн авлигыг мэдээлэх 110 дугаар сурталчлах ажлыг зохион байгуулсан байна. | Үйл ажиллагааны зардал | Улирал бүр | ЗУГ ГСҮХ         | ТОНОББ              |

|   |  |   |   |  |                        |          |              |        |
|---|--|---|---|--|------------------------|----------|--------------|--------|
|   |  |   | ашиглан иргэдэд сурталчлах  |  |                        |          |              |        |
|   |  | 1.3. Салбарын үйл ажиллагаанд авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий шторк, рийл, уриа зэрэг бүтээж, олон нийтэд хүргэсэн байх.                    | -сар бүр 1 бүтээл гаргах түгээсэн байх<br>-түгээлтийг ТОНОББ-тай хамтран зохион байгуулах   | - төрийн албан хаагчийн ёс зүйг харуулсан богино хэмжээний видео контент /Reel/-ийг бүтээж, ОБЕГ ба АТГ-ын ОНТ facebook хуудас байршуулсан байна.<br>-мөрдөгчийн мэдэгдэл хүлээж авсан орон нутгийн ОБГ-аас эхлэн сар бүр "нэгдье" аянд хамтарч байгаа, шударга байхыг уриалсан бүхий рийл, шторк зэргийг хийж цахимд оруулж түгээсэн байх   | Үйл ажиллагааны зардал | Сар бүр  | ЗЭЗХНГ ЗУГ   | ТОНОББ |
| 2 | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгаа зохион байгуулах | 2.1 Алба хаагчдад өмнө нь хүлээн авсан мөрдөгчийн мэдэгдлийн жишээ болгон танилцуулах, цаашид тухайн төрлийн гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах | Мөрдөгчийн мэдэгдэл, ОББ-д өмнө нь хүлээн авч байсан мөрдөгчийн мэдэгдлийн талаар байгууллагын алба хаагчдад танилцуулж, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх | - ТОНОББ-ын Хүний нөөц, бие бүрэлдэхүүний сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн нарын сургалтаар мөрдөгчийн мэдэгдэл, авлигын гэмт хэргийн талаарх сургалтыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.<br>- ТОНОББ-ын Хүний нөөц, бие бүрэлдэхүүний сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн нар тухайн байгууллагадаа сургалтаар мэдсэн мэдлэгээ бусдадаа хуваалцах ажлыг зохион байгуулна. | Үйл ажиллагааны зардал | 3 улирал | ЗЭЗХНГ, ГХСГ | ТОНОББ |

|   |  |   |   |  |                        |            |                         |            |
|---|--|---|---|--|------------------------|------------|-------------------------|------------|
|   |  | 2.2. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тухайн байгууллагаас цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах; | - Нэвтрүүлсэн цахим үйлчилгээний түйл ажиллагааны тайлан мэдээг тоо байдлаар гаргах<br>- Галын аюулгүй байдлын дүгнэлт авах хүсэлтийн хэрэгжилтийг хангах<br>- Нисдэг тэргээр эмнэлгийн тусламж авах үед шаардагдах мөнгөн зардал, баримт бичгийн мэдээллийг нээлттэй тавих | -E-Mongolia аппликейшний Галын аюулгүй байдлын дүгнэлт авах хүсэлтийн хэрэгжилтийг хангах, нисдэг тэргээр эмнэлгийн тусламж авах үед шаардагдах мөнгөн зардал болон бусад арга хэмжээний талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй байршуулах ажлыг зохион байгуулж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлсэн байна. | Үйл ажиллагааны зардал | 2-р улирал | ГТТГ, ЭУГ, ХМТГ         | 111-р анги |
| 3 | Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах | 3.1. Нэр хүндтэй, салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн ажилтан, ахмад гал сөнөөгчийг оролцуулсан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээнд татан оролцуулж шторк, контентыг бүтээх                         | -Шторк, контентыг хагас жилд 1, нийт 2 удаа бүтээх,<br>-түгээлтийг зохион байгуулж 30 000 доошгүй байх  | - 120 дугаар ангиас авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээнд татан оролцуулж шторк, контентыг дотоод нөөц бололцоондоо тулгуурлан бүтээж, Онцгой байдлын ерөнхий газрын facebook хуудсанд байршуулсан байна.   | 3 сая                  | Улирал бүр | ЭУГ                     | ТОНОББ     |
|   |  | 3.2. ОБЕГ ба Нийслэлийн ОБГ-аас 2020-2025 он хүртэлх хугацаанд зарласан тендерт оролцсон ААН-ын дунд "Төрийн албан хаагчдыг эрсдэлээс хамгаалах нь" сэдэвт сургалтыг хамтран зохион байгуулах                           | - Тендерт оролцсон байгууллагуудад санал хүргүүлж, сургалтыг зохион байгуулна.  | - ОБЕГ, НОБГ-ын 2020-2025 он хүртэл хугацаанд зарласан тендерт оролцсон байгууллагуудын судалгааг гаргаж, АТГ-тай хамтран сургалтыг зохион байгуулна.  | Үйл ажиллагааны зардал | 3 улирал   | САТГ, УНГ, ГХСГ         | АТГ, НОБГ  |
|   |  | 3.3. АТГ, ГСҮХ-тэй хамтран авлигаас ангид байх, урьдчилан сэргийлэх өдөрлөгийг зохион байгуулах   | - Авлигын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх өдөрлөгийг зохион байгуулна  | - ОБЕГ, ГСҮХ-ийн шинээр томилогдсон алба хаагчид, залуу алба хаагчдын дунд авлигын эсрэг урьдчилан сэргийлэх өдөрлөгийг АТГ-ын УССГХ-тэй хамтран зохион байгуулна  | Үйл ажиллагааны зардал | 4-р улирал | ЗЭЗХНГ, ГХСГ, ЭУГ, ГТТГ | АТГ, ГСҮХ  |

---oOo---